

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын
эрх ашгийг хамгаалах зарим арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1, 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3-т заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор 2005 оны 4 дүгээр сарын 28-ний өдрөөс хойш олон нийтээс хөрөнгө татах замаар үнэт цаасаа нийтэд гаргаж хувьцаат компани болсон компаниудын хувьцааны арилжаанд 2008 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс дараахь журам тогтоосугай:

а/ дээрх компаниудын хувьцааг худалдан авахаар өмнөх өдрийн хаалтын ханшаас доогуур өгсөн захиалгыг арилжаанд оруулахгүй байх;

б/ тухайн хувьцааны ханш нэрлэсэн үнийнхээ 75 хувьтай тэнцэх хэмжээнд хүрэх хүртэл энэ тогтоолын 1 дэх заалтын а-д заасныг баримтлан арилжааг явуулах;

в/ тухайн хувьцааны ханш нэрлэсэн үнийнхээ 75 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн тохиолдолд нэрлэсэн үнийн 75 хувьтай тэнцэх хэмжээнээс бага хэмжээтэй үнээр өгсөн худалдан авах захиалгыг арилжаанд оруулахгүй байх.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хугацаанд үнэт цаасаа нийтэд гаргах ажиллагаа нь эхэлсэн боловч хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа дуусаагүй хувьцаат компаниудын хувьд энэхүү тогтоолоор тогтоосон журам хамаарахгүй.

3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/, брокер, дилер, андеррайтерийн компаниудад тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ